



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 100

Мандалговь

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
анхдугаар хуралдааны тов, хэлэлцэх асуудал батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн анхдугаар хуралдааныг 2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 11.00 цагаас Мандалговь хотод хуралдуулсугай.

Хоёр. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.

- 2.1 Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулсан тухай аймгийн сонгуулийн хорооны илтгэл, төлөөлөгчөөр сонгогдсонд тооцох тухай тогтоол танилцуулах
- 2.2 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийг баталгаажуулах тухай
- 2.3 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааны дэг батлах тухай
- 2.4 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргыг сонгох тухай
- 2.5 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгч сонгох тухай
- 2.6 Аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэх тухай
- 2.7 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороод байгуулж, бүрэлдэхүүнийг батлах тухай

Гурав. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааны бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой санал шийдвэрийн төсөл боловсруулан ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Мөнгөнцоож), аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР





**ДУНГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 101

Мандалговь

**Хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Биеийн тамир спортын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 13,976,660 (арван гурван сая есөн зуун далан зургаан мянга зургаан зуун жар) төгрөгийн балансын үнэтэй, 2,886,276 (хоёр сая найман зуун наян зургаан мянга хоёр зуун далан зургаа) үлдэгдэл өртөгтэй 19 нэр төрлийн хавсралтад дурдсан эд хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Биеийн тамир спортын газрын дарга (М.Наранбадрах)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

- 2.1 Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг акталж, данснаас хасах, акталснаас гарах материалыг эргэлтийн хөрөнгөнд бүртгэж авахыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах.
- 2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх.
- 2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 4 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР





Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын Гэргүүлэгчдийн 2020 оны 10  
дугаар сарын 19-ний өдрийн  
101-тогтоолын хавсралт

**Биеийн тамир спортын газрын актлах хөрөнгийн мэдээлэл**

Барилга байгууламж

№	Үндсэн хөрөнгийн нэр			хэмжих нэгж	Өртөг		Улдэгдэл өртөг
	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Нэгжийн үнэ		Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	
1	Хашаа ,хаалга	2009-12-31	ш	11,075.10	465,154.20	465,154.20	0.00
2	Хашаа ,хаалга	2018-06-30	ш	16,800.00	1,041,600.00	451,360.00	590,240.00
3	Хашаа хашлага /Цэнгэлдэх /	2018-06-30	ш	49,261.18	3,743,849.68	1,622,355.34	2,121,494.34
				<b>77,136.28</b>	<b>5,250,603.88</b>	<b>2,538,869.54</b>	<b>2,711,734.34</b>

Авто тээврийн хэрэгсэл

1	Уралдааны дугуй	2009-12-31	ш	280,000.00	840,000.00	840,000.00	0.00
				<b>280,000.00</b>	<b>840,000.00</b>	<b>840,000.00</b>	<b>0.00</b>

Тоног төхөөрөмж

1	Тог баригч-39205	2010-08-01	ш	75,000.00	75,000.00	75,000.00	0.00
2	Ногбоок 15110-39205	2011-12-21	ш	935,000.00	935,000.00	935,000.00	0.00
3	Принтер 2012-39205	2012-08-01	ш	1,344,000.00	1,344,000.00	1,344,000.00	0.00
				<b>2,354,000.00</b>	<b>2,354,000.00</b>	<b>2,354,000.00</b>	<b>0.00</b>

Тавилга эд хогшил

1	Тумбочка	2002-01-01	ш	114,211.22	114,211.22	114,211.22	0.00
2	Тумбочка	2010-08-01	ш	132,000.00	132,000.00	132,000.00	0.00
3	Сандал	2010-08-01	ш	125,000.00	125,000.00	125,000.00	0.00
4	Ширээ	1991-01-01	ш	30,000.00	30,000.00	30,000.00	0.00
5	Хивс	2002-01-01	ш	189,945.00	189,945.00	189,945.00	0.00
6	Дрож	2008-09-01	м	28,000.00	364,000.00	364,000.00	0.00
7	Хашаа-39207	2006-06-01	ш	54,076.93	1,406,000.05	1,406,000.05	0.00
8	Гэдэс тогтоогч вандан	2012-06-30	ш	80,000.00	80,000.00	80,000.00	0.00
9	Ширээ 2012 он	2012-09-09	ш	320,000.00	320,000.00	320,000.00	0.00
10	Сандал 2012 он	2012-09-09	ш	260,000.00	260,000.00	260,000.00	0.00
11	Хүлээн авалтын ширээ	2017-12-31	ш	187,000.00	374,000.00	199,466.81	174,533.19
12	Ширээ 2013	2013-12-30	ш	212,300.00	636,900.00	636,900.00	0.00
				<b>1,732,533.15</b>	<b>4,032,056.27</b>	<b>3,857,523.08</b>	<b>174,533.19</b>
	Нийт дүн	<b>0.00</b>		<b>4,443,669.43</b>	<b>12,476,660.15</b>	<b>9,590,392.62</b>	<b>2,886,267.53</b>



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 102

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 15,000,000 (арван таван сая) төгрөгийн балансын үнэтэй, 15,000,000 (арван таван сая) төгрөгийн үлдэгдэл өртөгтэй приус 30 маркийн автомашиныг Дундговь аймгийн Цагдаагийн газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Оюунчимэг), Дундговь аймгийн Цагдаагийн газрын дарга (Г.Наранбаатар) нарт дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

- 2.1 Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
- 2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;
- 2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 4-р улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  ССҮХБААТАР





Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2020 оны 10 дугаар сарын  
19-ний өдрийн 102-тогтоолын хавсралт

**Сайнцагаан сумын балансаас балансад шилжүүлэх тээврийн хэрэгслийн мэдээлэл**

Д/Д	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
			Сери	дугаар						
1	Суудлын	Приус-30	ДУА	07-06	2010он	2020он	100,000	15,000,000	0	15,000,000
<b>Нийт дүн</b>										
								<b>15,000,000</b>		<b>15,000,000</b>
								<b>/арван таван сая/ төгрөг</b>		<b>/арван таван сая/ төгрөг</b>



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 103

Мандалговь

Г Монгол Улсын цол хүртээх, одон, Г  
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам”-ыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Соёл урлагийн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан Говь-Угтаал сумын өндөр настан Дуламын Дондовын Монгол Улсын Төрийн дээд шагнал “Соёлын гавьяат зүтгэлтэн”-цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр. Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Мөнгөнцоож)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 103

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,  
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам”-ыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Соёл урлагийн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан Говь-Угтаал сумын өндөр настан Дуламын Дондовын Монгол Улсын Төрийн дээд шагнал “Соёлын гавьяат зүтгэлтэн”-цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр. Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Мөнгөнцоож)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР





**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 104

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,  
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам”-ыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Дундговь аймгийн төр, төрийн бус байгууллага, боловсрол, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, санхүү, хэвлэл мэдээлэл, шуудан үйлчилгээ, авто тээврийн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан иргэдийн нэрсийг хавсралтаар баталж, Монгол Улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр. Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Мөнгөнцоож)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2020 оны 10 дугаар сарын  
19 ны өдрийн 104 тогтоолын хавсралт

**“Алтан гадас одон”-гоор:**

1. Лхагважавын Эрдэнэчимэг – Сайнцагаан сумын 7 дугаар багийн ахмад настан
2. Зундуйн Наранцэцэг – Сайнцагаан сумын 7 дугаар багийн ахмад настан

**“Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар:**

1. Гомбын Сумъяа – Сайнцагаан сумын харьяат, Эрдмийн далай цогцолбор сургуулийн ахмад настан
2. Мишигийн Довдонбалжир – Цагаандэлгэр сумы харьяат, өндөр настан
3. Дэндэвийн Энхжаргал – Цагаандэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн ахрмад настан



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 104

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,  
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам”-ыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


Нэг. Дундговь аймгийн төр, төрийн бус байгууллага, боловсрол, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, санхүү, хэвлэл мэдээлэл, шуудан үйлчилгээ, авто тээврийн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан иргэдийн нэрсийг хавсралтаар баталж, Монгол Улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр. Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Мөнгөнцоож)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2020 оны 10 дугаар сарын  
19 ны өдрийн 104 тогтоолын хавсралт

**“Алтан гадас одон”-гоор:**

1. Лхагважавын Эрдэнэчимэг – Сайнцагаан сумын 7 дугаар багийн ахмад настан
2. Зундуйн Наранцэцэг – Сайнцагаан сумын 7 дугаар багийн ахмад настан

**“Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар:**

1. Гомбын Сумъяа – Сайнцагаан сумын харьяат, Эрдмийн далай цогцолбор сургуулийн ахмад настан
2. Мишигийн Довдонбалжир – Цагаандэлгэр сумы харьяат, өндөр настан
3. Дэндэвийн Энхжаргал – Цагаандэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн ахрмад настан